

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН  
ЯАМНЫ ДЭРГЭДЭХ САЛБАР ЗӨВЛӨЛ**

**4 дүгээр хуралдаанаар хэлэлцсэн асуудлын тойм №4  
2017.11.24**

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Яамны Усны нөөцийн хэлтсийн даргын сонгон шалгаруулалт явуулсан дүн, тухайн ажлын байрны албан тушаалд дүгнэлт гаргуулах, нэр дэвшүүлэх тухай танилцуулах	1.Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Газар зохион байгуулалт, усны нэгдсэн бодлого зохицуулалтын газрын Усны нөөцийн хэлтсийн даргын албан тушаалд Лувсандоржийн Эрдэнэбулганыг томилуулахаар нэр дэвшүүлж, Төрийн нарийн бичгийн даргад санал болгохоор Салбар зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.
2	Тангараг өргүүлэх тухай	1. Төрийн албаны тухай хуулийн 12 дугаар зүйлд заасны дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас 11, Цаг уур орчны шинжилгээний газраас 1, Хан Хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаанаас 2, хавсралтад дурдсан нэр бүхий 14 иргэнийг Төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргүүлэхээр Салбар зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов. 2. Төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргөх ёслолын ажиллагааг 2017 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 14 <sup>00</sup> цагаас ХААН танхимд Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1995 оны 109 дүгээр зарлигаар баталсан журмын дагуу зохион байгуулахыг Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, холбогдох нэгжийн удирдлагууд, албан хаагчдад үүрэг болгов.
3	Г.Ганзоригт, Д.Ариунжаргал, Т.Эрдэнэчимэг нарын өргөдлийн тухай	1.М.Ариунжаргалыг байгаль хамгаалагчаар эгүүлэн авахдаа байгаль хамгаалагчийн хариуцах хэсгийг өөрчлөх талаар Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны дарга Ц.Дуламсүрэнд Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөс даалгав.  2.Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны мэргэжилтнээр ажиллаж байгаад ажлаас халагдсан Г.Ганзоригтын гомдлыг өөрийг нь байлцуулан мөн Богдхан уулын дархан

		<p>цаазат газрын хамгаалалтын захиргааны дарга Ц.Дуламсүрэн, Яамны ёс зүйн хорооны дарга, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Т.Алтангэрэл нарыг байлцуулан Ёс зүйн хорооны дүгнэлтийг үндэслэн 1 дэх өдрийн удирдах ажилтны шуурхай зөвлөгөөний дараа шийдвэрлүүлэх нь зүйтэй гэж үзэв.</p> <p>3. Нийслэлийн Чингэлтэй дүүрэг дэх Цагдаагийн Нэгдүгээр хэлтсийн Мөрдөн байцаах тасгийн дарга Хошууч Б.Алтангадасаас 2017-11-22-ны өдрийн 14<sup>с-3</sup>/5954 дугаар албан бичгээр Улсын Ерөнхий прокурорын орлогч Б.Амгаланбаатар нь иргэн Ч.Бээжинхүүгийн гаргасан гомдлын дагуу 2017 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 1/572 дугаартай “Хэргийг хэрэгсэхгүй болгох тухай прокурорын тогтоолыг хүчингүй болгож, мөрдөн шалгах ажиллагаа явуулах” тухай тогтоол үйлдэн мөрдөн шалгах ажиллагааг сэргээн явуулж байгаа тухай хариу ирүүлсэн байна. Иймд дээрх 201301051030 дугаартай хэргийг шийдвэрлэгдтэл хугацаагаар уг өргөдлийг шийдвэрлэх боломжгүй хариуг Яамны Хуулийн хэлтсээс Т.Эрдэнэчимэгт хүргүүлэх нь зүйтэй гэж үзэв.</p>
4	<p>Бусад асуудал /Зэд-Хантай-Бүтээлийн нурууны хамгаалалтын захиргааны, Увс нуурын ай савын улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны даргын ажлын байрны сул орон тооны тухай/</p>	<p>1.Тус яамны харъяа Зэд-Хантай-Бүтээлийн нурууны хамгаалалтын захиргааны, Увс нуурын ай савын улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны даргын, Цаг уур, орчны шинжилгээний газрын Улсын сүлжээ, уур амьсгалын үйлчилгээний хэлтсийн болон Урьдчилан мэдээлэх хэлтсийн даргын албан тушаалын сул орон тооны захиалгын дагуу сонгон шалгаруулах нэг Ажлын хэсэг байгуулахыг Тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газрын дарга Ч.Батсансар, Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга С.Энхтүвшин нарт үүрэг болгов.</p>

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн дугаар хуралдаан 2017 оны 11 дүгээр сарын 24-ний өдрүүдийн 15 цаг 00 минутаас 301 тоот өрөөнд болно.

Салбар зөвлөлийн хуралдаан №4 (2017.11.24)